

1.1 Ирсэн асуулгад хариулах

"Асуулга" үйл ажиллагааны мэдээллийг удирдах зааварчилгаа

Энэхүү дэд бүлэгт асуулга цонхны ерөнхий ойлголт, асуулгад хариулах, баталгаажуулах зааврыг танилцуулна. Асуулга гэдэг нь нийт хэрэглэгчдээс судалгаа авах, мэдээлэл цуглуулах үед ашиглагддаг хэрэгсэл юм. Асуулга бүр нь дотроо хэд хэдэн асуулт агуулсан байна.

Ирсэн асуулгад хариулах үйл явцын зааварчилгаа

Системийн үндсэн цэснээс **Асуулгын удирдлага** цэсийг сонгоход **Ирсэн асуулга, Нэгтгэл** гэсэн 2 цэс харагдана. Ирсэн асуулга цэсийг сонгоход асуулгуудын жагсаалт бүхий дараах цонх дуудагдана.

Ирсэн асуулга						
Асуулга хайх ...						
[Асуулгад хариулах] [Баталгаажуулах]						
№	Асуулга	Асуулга эхлэх	Асуулга дуусах	Хүсэлт илгээсэн	Хариулсан тоо	Баталгаажуулалт
1	СӨБ Сургалт	2017-09-15	2017-09-30		1	Батлагдсан

Хариулт						
№	Тайлбар	Баталгаажсан эсэх	Үүсгэсэн	Огноо	Үйлдэл	
1		<input checked="" type="checkbox"/>	ES3310851008	2017-09-15		

Жагсаалтаас асуулгыг сонгож **Асуулгад хариулах** товчийг дарж асуулгад хариулах боломжтой.

Нэг асуулгад олон хариулах тохиргоотой бол хариулт бүр нь цонхны доод хэсэгт хариултын жагсаалтад харагдана. Хариултыг өөрчлөх, устгах бол хариулт бүрийн ард байрлах үйлдлээс сонгох боломжтой.

Сургалтанд оролцогчдын бүртгэл, мэдээлэл

Сургалтанд оролцогчдын бүртгэл, мэдээлэл

1) Оролцогчийн мэдээлэл

1.1) Иргэний харьяалал

 Монгол Гадаад

1.2) Улс

1.3) Регистрийн дугаар

1.4) Эцэг /эх/-ийн нэр

1.5) Өөрийн нэр

1.6) Нас

1.7) Албан тушаал

1.8) Боловсролын түвшин

 Доктор Магистр Бакалавр Диплом Тусгай дунд Бүрэн дунд

1.9) Ажлын утас

1.10) Гар утас

1.11) И-мэйл хаяг

2) Байгууллагын мэдээлэл

2.1) Байгууллага дотоод сүлжээтэй эсэх

 Тийм Үгүй

2.2) Байгууллага интернэтэд холбогдсон эсэх

 Тийм Үгүй

2.3) Танай байгууллага хэдэн компьютер ашиглаж байна вэ?

2.4) Цэцэрлэгийн гадна орчинд хяналтын камертай эсэх

 Тийм Үгүй

2.5) Цэцэрлэгийн дотоод орчинд хяналтын камертай эсэх

 Тийм Үгүй

2.6) Сургалт болон системтэй холбоотой таны санал...